



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Цант-Орхон" ААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/024/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:

www.selenge@audit.gov.mn

Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх

Утас: 70363040

Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор:

Ц.Отгонбаяр

Утас: 70363036

Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn

Аудитын гүйцэтгэсэн: "Мэдээлэл аудит" ХХК-ийн Сэлэнгэ салбар

Утас: 99499667

Цахим хаяг: infoauditselenge@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



“ЦАНТ ОРХОН” ААТҮГ-ЫН
ДАРГА Ц.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № СЭА-2026/024/НА-СТА-ОНӨҮГ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Цант-Орхон” ААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Цант-Орхон” ААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Цант-Орхон” ААТҮГ нь тайлант онд Сэлэнгэ аймгийн ОНӨГ-ын 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 237 дугаар албан тоотын дагуу ашиглалтын хугацаа дууссан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч дахин ашиглах боломжтой 53 нэр төрлийн 101,679.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаж ашиглах хугацааг сунгаж 9,752.3 мянган төгрөгөөр орлогод авч, байгууллагын эзэмшлийн 332,717 м2 газрыг “Арвижих эстимейт үнэлгээ” ХХК-иар бодит үнэ цэнээр үнэлүүлснээр газрын үнэлгээ 3,761.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант оны орлогыг 1,535,475.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,790,984.1 мянган төгрөгөөр тогтоосон бөгөөд гүйцэтгэлээр 1,719,902.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,775,581.3 мянган төгрөгийн зардал гарган, 55,679.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Нийт орлогын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс 184,427.0 мянган төгрөг буюу 112.0 хувиар биелж, нийт зардал төлөвлөсөн зардлыг 0.9 хувиар буюу 15,402.8 мянган төгрөгөөр хэмнэсэн.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Цант-Орхон” ААТҮГ-ын 2025 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93.0 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнасан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	333,054,080.66	150,400,356.53
1.1.2	Дансны авлага	13,827,275.43	5,189,461.96
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		2,749,207.40
1.1.6	Бараа материал	101,333,421.48	160,122,274.75
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	448,214,777.57	318,461,300.64
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	9,502,964,510.13	5,820,965,624.23
1.2.2	Биет бус хөрөнгө		
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	9,502,964,510.13	5,820,965,624.23
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,951,179,287.70	6,139,426,924.87
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	4,641,023.40	15,000.00
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,641,023.40	15,000.00
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	4,641,023.40	15,000.00
2.3	Эздийн өмч	-	-
2.3.1	Өмч: - төрийн	1,893,696,135.00	1,893,696,135.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	9,235,812,230.39	5,484,363,516.39
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	58,300,000.00	58,300,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,241,270,101.09)	(1,296,947,726.52)
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг	(207,959,341.67)	(55,677,625.43)
2.3.9	Өмнөх үеийн ашиг	(1,033,310,759.42)	(1,241,270,101.09)
2.3.11	Эздийн өмчийн дүн	9,946,538,264.30	6,139,411,924.87
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	9,951,179,287.70	6,139,426,924.87

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,264,290,141.74	1,701,788,825.51
2	Борлуулалтын өртөг	1,335,422,903.44	1,682,036,171.56
3	Нийт ашиг (алдагдал)	(71,132,761.70)	19,752,653.95
4	Түрээсийн орлого	12,410,909.05	11,000,909.02
5	Хүүний орлого	5,087,461.60	3,174,822.85
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	31,998,826.62	3,937,512.64
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	51,161,426.38	85,926,499.16
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	7,381,373.64	6,778,638.65
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(127,780,977.22)	(840,000.00)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(207,959,341.67)	(55,679,239.35)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(207,959,341.67)	(55,679,239.35)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(207,959,341.67)	(55,679,239.35)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(207,959,341.67)	(55,679,239.35)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,937,114,135.00	14,574,144,861.64	-	(1,078,006,335.14)	15,433,252,661.50
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	(43,418,000.00)			43,418,000.00	-
3	Залруулсан үлдэгдэл					-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(207,959,341.67)	(207,959,341.67)
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт			58,300,000.00		58,300,000.00
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(5,338,332,631.25)		1,277,575.72	(5,337,055,055.53)
9	2024 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,893,696,135.00	9,235,812,230.39	58,300,000.00	(1,241,270,101.09)	9,946,538,264.30
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-	-
11	Залруулсан үлдэгдэл					
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(55,679,239.35)	(55,679,239.35)
13	Бусад дэлгэрэнгүй орлого					-
14	Өмчид гарсан өөрчлөлт					
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(3,751,448,714.00)			(3,751,448,714.00)
17	2025 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,893,696,135.00	5,484,363,516.39	58,300,000.00	(1,296,949,340.44)	6,139,410,310.95

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024оны 12-р сарын 31	2025оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	1,470,181,523.76	1,888,379,819.10
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,470,181,523.76	1,888,379,819.10
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,414,399,553.27	1,876,427,068.25
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	3,510,955.00	1,228,693.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	52,271,015.49	10,724,057.85
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,343,256,405.57	1,808,487,583.23
1.2.1	Ажиллагчдад төлсөн	579,928,325.44	737,126,179.98
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	166,612,293.29	188,367,161.53
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	290,810,090.00	366,059,892.01
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	71,367,094.72	141,997,445.74
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	53,925,440.00	74,208,000.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	152,009,135.52	206,630,161.21
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	2,465,916.60	2,318,962.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	26,138,110.00	91,779,780.76
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	126,925,118.19	79,892,235.87
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	209,293,050.00	221,537,325.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	209,293,050.00	221,537,325.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(209,293,050.00)	(221,537,325.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	16,644,320.00	41,008,635.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Бусад	16,644,320.00	41,008,635.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(16,644,320.00)	(41,008,635.00)
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(99,012,251.81)	(182,653,724.13)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	432,066,332.47	333,054,080.66
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	333,054,080.66	150,400,356.53

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Орлогын нийт дүн	1,535,475,050.00	1,719,902,070.02	(184,427,020.02)	112.0
Цэвэр борлуулалтын дүн	1,535,475,050.00	1,719,902,070.02	(184,427,020.02)	112.0
Цэвэр усны борлуулалт	17,800,000.00	19,494,651.95	(1,694,651.95)	109.5
Бохир усны борлуулалт	1,331,321,550.00	1,499,157,618.88	(167,836,068.88)	112.6
Халуун усны орлого	100,593,500.00	101,991,147.69	(1,397,647.69)	101.4
Зочид буудлын орлого	77,760,000.00	90,444,469.70	(12,684,469.70)	116.3
Бусад орлого	8,000,000.00	8,814,181.80	(814,181.80)	110.2
Нийт зардлын дүн	1,790,984,092.00	1,775,581,309.37	15,402,782.63	0.9
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,738,906,075.71	1,682,036,171.56	56,869,904.15	3.3
Ерөнхий удирдлагын зардал	50,078,016.29	86,766,499.16	(36,688,482.87)	(73.3)
Үйл ажиллагааны бус зардал	2,000,000.00	6,778,638.65	(4,778,638.65)	
Цэвэр ашиг алдагдал	(255,509,042.00)	(55,679,239.35)	(199,829,802.65)	78.2

ГУРАВ. Аудитын илрүүлэлт

3. Залруулсан алдаа:

Аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой нийт **12,509.9** мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Төрийн өмчийн дүнг 9,752.3 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Санхүүгийн тайланд татварын өр төлбөрийг 8.3 мянган төгрөгөөр илүү, авлагыг 2,749.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд НББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт **266,452.3** мянган төгрөгийн 5 зөрчил¹ илэрснээс 9,850.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 256,602.3 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **9,850.0** мянган төгрөгийн материаллаг залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5,367.5 мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

1.Тайлант онд аймгийн Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 01/1336 дугаар албан тоот, байгууллагын даргын 10 дугаар сарын 10-ны өдрийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Б/88, Б/91, А/15 дугаар тушаалуудаар Олон улсын ахмадын баяр, Монгол улсын нийтийн аж ахуйн үйлчилгээний салбар үүсэж хөгжсөний 94 жилийн ой, Нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээний ажилтны 47 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой 6,350.0 мянган төгрөгийн, 12 дугаар сарын 28-ны өдрийн Б/114 дүгээр тушаалаар байгууллагын аварга ажилтныг шалгаруулан 6 ажилтанд нийт 3,500.0 мянган төгрөгийн шагнал олгосон зэрэг нийт 9,850.0 мянган төгрөгийн зардал гаргасан байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3 дахь “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой

1.1 Илрүүлэлт: Тайлант онд тооцооны дансаар дамжуулалгүйгээр 10,397.1 мянган төгрөгийн татварын /авто, үл хөдлөх, газар/, 126,407.4 мянган төгрөгийн ашиглалтын, шуудан холбооны, сургалтын гэх зэрэг зардлуудыг шууд зардлаар бүртгэж тайлагнаснаас өр, авлага тайлагнагдахгүй байх эрсдэлийг бий болгож байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ...”, гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Ангилал” батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Зардлыг тооцооны дансаар дамжуулан бүртгэл тайланд тусгаж байх.

2. Татварын тайлагналтай холбоотой

2.1 Илрүүлэлт Шагнал, тэтгэмж урамшууллын зардал 4,120.0 мянган төгрөгөөс татварыг суутган тооцоолж, татварын албанд тайлагнаагүй байгаа нь татварын өр үүсэх эрсдэлтэй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх “урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал болон

тэдгээртэй адилтгах бусад орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн орлогын дүнгээр;” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Татварын тооцооллыг үнэн зөв хийж, тайлагнаж байх.

3. НӨАТ-ын бүртгэл, тайлагналтай холбоотой

3.1 Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлд дансны бичилтийг буруу хийснээр 97,031.5 мянган төгрөгийн худалдан авалтыг НӨАТ салгалгүй бүртгэсэн, НӨАТ төлөгч биш харилцагчаас авсан 18,646.0 мянган төгрөгийн худалдан авалтыг НӨАТ салган бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх “*Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*”, 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн байна

3.2 Өгсөн зөвлөмж: НӨАТ-ыг анхан шатны баримтыг үндэслэн үнэн зөв бүртгэн тайлагнаж байх.

4. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой

4.1 Илрүүлэлт: Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд 8 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй боловч татварын бүртгэлд 13 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй /*тайлант онд бүртгэлээр байхгүй 7237СБА тээврийн хэрэгслийн татвар ногдуулан төлсөн*/ байгаа нь татвар илүү ногдуулах татварын өр төлбөр үүсэх эрсдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Оршин байх” батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн байна.

4.2 Өгсөн зөвлөмж: Байгууллагын эзэмшилд байхгүй тээврийн хэрэгслийг татварын бүртгэлээс хасуулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн өмчийн дүнг илүү тайлагнасан	1	9,752.3			1	9,752.3	1	9,752.3				
Авлага, өр төлбөр дутуу тусгасан	1	2,757.6	1	2,757.6			1	2,757.6				
Дүн	1	12,509.9	1	2,757.6	1	9,752.3	1	12,509.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн	1	136,804.8					1	136,804.8				
Шагнал, тэтгэмж урамшууллыг татварт тайлагнаагүй	1	4,120.0					1	4,120.0				
НӨАТ-ыг буруу бүртгэн тайлагнасан	1	115,677.5					1	115,677.5				
Татварт тээврийн хэрэгслийг илүү тайлагнасан	1	-					1	-				
Дүн	5	256,602.3					4	256,602.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
Дүн											

Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Ой тэмдэглэн өнгөрүүлэх, шагнал урамшууллын зардал гаргасан.	1	9,850.0			1	9,850.0			
Дүн	1	9,850.0			1	9,850.0			
Нийт дүн	1	9,850.0			1	9,850.0			

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			